

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2011 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Илтгэгч нь: Ерөнхий шүүгч Ц.Зориг

Эрхэм шүүгч, ажилтнуудаа!

Улиран өнгөрч буй 2011 онд бид шүүхийн шинэтгэлийг эрчимжүүлэх, түүн дотроо шүүхийн, шүүгчийн, шүүн таслах ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож Шүүхийн багц хуулийн төсөл боловсруулахад хамтран ажиллах, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийг шинээр байгуулах, шүүхийн захиргааны удирдлагыг зорилтот стратегид суурилсан алсын хараатайгаар хэрэгжүүлэх, шүүхийн гадаад харилцааг өргөжүүлэх, харилцан найрсаг хамтын ажиллагааг бэхжүүлэх, гадаадын зарим орнуудтай хамтран зохион байгуулж буй шүүгчдийн сургалтыг тогтмолжуулах, түүний үр нөлөөг дээшлүүлэх, “Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөрийг шүүхэд хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх үндсэн чиглэл”-н дагуу тодорхой зарим арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлэх зэрэг зорилтыг тус тус дэвшүүлэн ажилласан бөгөөд энэ чиглэлүүдэд зарим тодорхой үр дүн, ахиц гарч үүнд та бүхний идэвхи зүтгэл, санал санаачлага хамгаас чухал байсныг тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Түүнчлэн бүх шатны шүүхийн нийт шүүгч, ажилтнуудад хандаж “Шүүхийн шинэтгэлийг эрчимжүүлэхэд шүүгч, захиргааны ажилтнуудын идэвхи, санаачлагыг дээшлүүлэх” уриалга, мөн Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Ерөнхий прокурор нарын 2011 оны 6 дугаар сард “Хуулийн байгууллагын ажилтнуудын сахилга, хариуцлагыг сайжруулах” хамтарсан захирамж, тушаалыг батлан гаргаж, нийт шүүхүүдэд хүргүүлж, тэдгээртэй холбоотой тодорхой зарим ажлуудыг хэрэгжүүллээ.

Өнгөрч буй 2011 он ажил хөдөлмөр өрнүүн, амжилт бүтээлээр арвин жил байлаа.

Та бидний хөдөлмөр зүтгэлийг төр өндрөөр үнэлж, Шүүх байгуулагдсаны 85 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шүүгч Л.Бямбаа “**Монгол Улсын Гавьяат хуульч**” цолоор, шүүгч Ц.Сумъяа “**Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон**”-оор, шүүгч Ч.Тунгалаг, Судалгааны төвийн захирал Ч.Нямсүрэн нар “**Алтан гадас**” одонгоор, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн ахлах референт Н.Долгорсүрэн, Санхүү, Хангамж хариуцсан референт-Ерөнхий нягтлан бодогч А.Эрдэнэцэцэг, Төсвийн асуудал хариуцсан шинжээч-нягтлан бодогч Б.Хишигсүрэн, Шүүгчийн туслах-шинжээч Д.Алтанцэцэг нар “**Хөдөлмөрийн хүндэт медаль**”-аар тус тус шагнагдлаа.

Мөн Ардын хувьсгалын 90 жилийн ойн медалиар шүүгч, ажилтан 22 хүн шагнагджээ.

Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Д.Батсайхан, Захиргааны хэргийн танхимын тэргүүн О.Зандраа, шүүгч Ц.Амарсайхан, Тамгын газрын дарга Д.Эрдэнэчулуун нар Улсын Дээд шүүхийн “**Хүндэт тэмдэг**”-ээр, Иргэний хэргийн танхимын тэргүүн Б.Ундрах, шүүгч Л.Атарцэцэг нар “**Шүүхийн тэргүүний ажилтан**” цол, тэмдэгээр, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга Р.Ганпүрэв, Ерөнхий шүүгчийн шүүн таслах ажиллагаа хариуцсан референт З.Нацаг нар Шүүхийн Ерөнхий зөвлөлийн “**Хүндэт тэмдэг**”-ээр, шүүгчийн туслах-шинжээч Д.Алтанжигүүр, бичиг хүргэгч А.Пүрэвдулам, нярав Б.Отгонцэрэн, жолооч Д.Төмөрхуяг, үйлчлэгч Д.Загдсүрэн нар Улсын Дээд шүүхийн “**Жуух бичиг**”-ээр, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний туслах-ахлах шинжээч Ө.Уянга, шүүгчийн туслах-шинжээч И.Амартөгс нар Монголын Залуучуудын Холбооны “**Тэргүүний залуу алтан медаль**”-аар тус тус шагнагдлаа.

Түүнчлэн Монгол Улсад Хууль зүйн алба үүсч хөгжсөний 100 жил, шүүх байгуулагдсаны 85 жилийн ойг тохиолдуулан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ хараат бус байж, гагцхүү хуульд захирагдан ажиллаж, аливаа хэрэг, маргааныг хуульд нийцүүлэн шийдвэрлэж, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, шүүхийн өөрчлөлт, шинэчлэлтэд зохих хувь нэмэрээ оруулж байгаа, боловсролын байгууллагад идэвхи зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, хууль зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэх, эрх зүйч боловсон хүчнийг бэлтгэх, санхүүгийн мэдээ, тайланг цаг тухайд гаргаж, төсвийн мөнгөн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, шүүхийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэхэд үр бүтээл гарган ажиллаж байгаа зэргийг нь үнэлж Сэлэнгэ аймгийн шүүхийн шүүгч Д.Буянжаргал, Увс аймгийн шүүхийн шүүгч Р.Үүрийнтуяа, Хөвсгөл аймгийн шүүхийн шүүгч Б.Оюунцэцэг, Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий

шүүгч М.Нармандах, Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Л.Батжаргал, Өвөрхангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч Б.Оюунцэцэг, Өмнөговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Б.Мөнхжаргал, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны дэд дарга, ахлах дэслэгч Р.Энхтайван, Сүхбаатар аймгийн Шийдвэр гүйцэтгэх албаны ахлах шийдвэр гүйцэтгэгч, ахлах дэслэгч Ц.Аваасүрэн, Согтуурах, мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын дэд дарга, дэд хурандаа Б.Энхтайван, Шихихутуг Хууль зүйн дээд сургуулийн багш Б.Цэрэнчимэд, Говьсүмбэр аймгийн шүүхийн нягтлан бодогч Д.Бадамгэрэл, Дорноговь аймгийн Замын-Үүд дэх Сум дундын II шүүхийн нягтлан бодогч А.Одончимэг, Нийслэлийн Багануур дүүргийн шүүхийн нягтлан бодогч Х.Бадамжаргал, Өвөрхангай аймгийн шүүхийн бичиг хүргэгч Б.Мягмарсүрэн, Сэлэнгэ аймаг дахь сум дундын 3 дугаар шүүхийн бичиг хүргэгч М.Ариунаа, Өмнөговь аймгийн шүүхийн бичиг хүргэгч Д.Гантулга нарын 17 хүн Ерөнхий шүүгчийн захирамжаар Улсын Дээд шүүхийн “Жуух бичиг”-ээр тус тус шагнагджээ.

2011 онд шүүгч Б.Ундрахыг Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүний, Т.Уранцэцэгийг Улсын Дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гарлаа.

Улсын Дээд шүүхээс 2011 онд дараах бүтээлийг эрхлэн хэвлүүллээ. Тухайлбал,

- “Иргэний эрх зүйн хамгаалалт ба шүүхийн практик” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүдийн эмхтгэл;
- “Монголын шүүхийн товчоон” нэг сэдэвт бүтээл;
- “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр” –ийн эмхтгэл;
- “Шүүхийн 2010 оны ажлын тайлан” зэргийг хэвлүүлж, олон нийтийн хүртээл болголоо.

2011 оны 2 дугаар сарын 16-ны өдөр Шүүгчдийн зөвлөл хуралдаж, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүнээр:

- Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч Б.Сарантуяа
- Орхон аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч П.Батсайхан
- Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч Ё.Цогтзандан нарыг;

Шүүхийн Мэргэшлийн хорооны гишүүнээр:

- Улсын Дээд шүүхийн шүүгч Б.Бат-Эрдэнэ нарыг тус тус сонгов.

Мөн хурлаар Шүүхийн мэргэшлийн болон Сахилгын хороо, Шүүгчдийн холбооны 2010 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хэлэлцлээ.

Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын шүүн таслах ажиллагааны дүн мэдээ болон Танхимууд, Тамгын газрын тайлан гарлаа. Ингээд Улсын Дээд шүүхийн 2011 оны **Нэгдсэн тайланг** товч танилцуулъя.


Нэг. Шүүн таслах ажиллагааны талаар

Нийт шүүгчдийн хуралдаан:


2011 онд нийт шүүгчдийн хуралдааныг 5 удаа зарлан, нийт 5 өдөр хуралдуулж, бүгд 10 асуудал хэлэлцэж, 10 тогтоол гаргасны дотор эрүүгийн хэрэг 3, иргэний хэрэг 1, бусад асуудал 6-ийг тус тус хэлэлцэн шийдвэрлэж, **Өвөрхангай, Хөвсгөл, Говь-Алтай, Дундговь, Говьсүмбэр** аймгийн анхан болон давж заалдах шатны шүүх, захиргааны хэргийн шүүхүүдийн ажилтай танилцан, мэргэжлийн удирдлагаар хангасан тухай тэмдэглэл гаргажээ.

Өнгөрсөн 2010 онтой харьцуулахад Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тоо 20-оор, эрүүгийн хэрэг 10-аар, иргэний хэрэг 2-оор тус тус буурч, бусад асуудал 2-оор нэмэгдсэн байна.

Нийт шүүгчдийн хуралдааны үзүүлэлт



Нийт шүүгчдийн хуралдааны 2010-2011 оны харьцуулалт




2011 оны шүүн таслах ажиллагааны тайланг танхим тус бүрээр товч танилцуулбал:

1. Эрүүгийн хэргийн танхим:

Эрүүгийн хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл 34 хэрэг дээр нэмж, хяналтын журмаар эрүүгийн 467, цагаатгалын 248, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 356 дугаар зүйлийн 356.1-д заасан үндэслэлээр 2, Ерөнхий шүүгчид хандаж гомдол гаргасан 71, нийт 822 хэрэг хүлээн авчээ.

Тайлангийн хугацаанд эрүүгийн 456, цагаатгалын 245, нийт 701 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар, нийт шүүгчдийн хуралдаанаар 3 хэргийг тус тус хянан шийдвэрлэж, 43 хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зохих заалтуудыг зөрчсөн, гомдол гаргах хугацаа хэтэрсэн үндэслэлээр буцааж, 72 хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, одоо 3 хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авсан 822 хэргээс



Эрүүгийн хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт **49** өдөр хуралдаж, **өдөрт** дунджаар **14.3** хэрэг хянан шийдвэрлэжээ.


Хяналтын журмаар хянагдсан эрүүгийн **456** хэргийн **55.1** хувь буюу **251** хэргийн тогтоол, магадлалыг хэвээр үлдээн, гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, **19.1** хувь буюу **87** хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулж, **25.8** хувь буюу **118** хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгосон байна.

Өөрчлөлт оруулсан **87** тогтоол, магадлалын **33.3** хувь буюу **29** нь Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн, **5.8** хувь буюу **5** нь шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, **4.6** хувь буюу **4** нь хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, **5.8** хувь буюу **5** нь Эрүүгийн хуулийн 55^{1.1}, 62^{1.1}-д зааснаар, **4.6** хувь буюу **4** нь хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн байсан бол шийтгэх тогтоол, магадлалд **45.9** хувь буюу **40** –д бусад өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болсон **118** тогтоол, магадлалтай хэргээс **68** хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр **прокурорт**, **20** хэргийг анхан шатны **шүүхээр дахин хэлэлцүүлэхээр** буцааж, **16** хэргийг **хэрэгсэхгүй** болгож, **11** хэргийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгосон бол шийтгэх тогтоол, магадлалын зарим заалтыг хүчингүй болгосон хэрэг **3** байна.


Хяналтын журмаар Танхимын тэргүүн Д.Батсайхан **1**, шүүгч Б.Бат-Эрдэнэ **136**, С.Нямжав **133**, Д.Пунцаг **123**, С.Батдэлгэр **106**, Ерөнхий шүүгчийн ажлын алба **73** эрүүгийн хэрэг тус тус **хүлээн** авчээ.

Шүүгч тус бүрийн болон Ерөнхий шүүгчийн ажлын албаны хүлээн авсан хэрэг



Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд шүүгч С.Нямжав **637**, С.Батдэлгэр **618**, Б.Бат-Эрдэнэ **558**, Д.Пунцаг **534** удаа тус тус **оролцсоноос**;

- шүүгч Б.Бат-Эрдэнэ **186**, С.Нямжав **143**, Д.Пунцаг **72**, С.Батдэлгэр **71** хэргийн шүүх хуралдааныг тус тус **даргалж**;
- шүүч С.Нямжав **182**, Б.Бат-Эрдэнэ **179**, Д.Пунцаг **177**, С.Батдэлгэр **163** хэрэг тус тус **илтгэсэн** байна.



Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн цагаатгалын **245** хэргээс **268** хүнд холбогдох **243** хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгон тэднийг цагаатгаж, **2** хэргийн тогтоолд овог, нэрийг нь зөвтгөсөн өөрчлөлт оруулжээ.

Нийт шүүгчдийн хуралдаанаар эрүүгийн **3** хэргийг хянан хэлэлцсэн байна.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн **456** хэргийн **86.4** хувь буюу **394** нь ялтан, өмгөөлөгч, хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгчийн **гомдлоор**, **8.5** хувь буюу **39** нь улсын яллагчийн **эсэргүүцлээр**, **5.1** хувь буюу **23** нь прокурорын **дүгнэлтээр** хэлэлцэгджээ.

Тайлангийн хугацаанд Танхимын тэргүүн **Д.Батсайхан 1**, шүүгч **Б.Бат-Эрдэнэ 20**, **С.Нямжав 14**, **С.Батдэлгэр 5**, **Д.Пунцаг 3** хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зохих заалтуудыг зөрчсөн, гомдол гаргах хугацаа хэтэрсэн үндэслэлээр, Ерөнхий шүүгчийн ажлын алба **63** хэргийг тус тус хянан зохих хариуг өгөх байдлаар буцаасан байна.

Тус танхим 2011 онд нийт **26** албан бичиг, **68** өргөдөл, гомдол хүлээн авснаас шүүгч **Б.Бат-Эрдэнэ** албан бичиг **10**, өргөдөл гомдол **2**, **С.Нямжав** албан бичиг **7**, өргөдөл гомдол **5**, **С.Батдэлгэр** албан бичиг **2**, өргөдөл гомдол **2**, **Д.Пунцаг** албан бичиг **2**-ийг хүлээн авч хариу өгчээ.

Цагаатгалын асуудал хариуцсан шинжээч **Л.Одончимэг** албан бичиг **4**, өргөдөл гомдол **52**-т зохих албан тушаалтнуудаар хариуг өгүүлж, одоо цагаатгалын ажилтай холбоотой **7** өргөдөл, **1** албан бичгийн үлдэгдэлтэй байна.

Хяналтын шатны **иргэний** хэргийн шүүх хуралдаанд:

Шүүгч **Д.Пунцаг 29**, **С.Нямжав 13**, **С.Батдэлгэр 11**, **Б.Бат-Эрдэнэ 8**, удаа тус тус оролцжээ.

Харин хяналтын шатны **захиргааны** хэргийн шүүх хуралдаанд:

Шүүгч **Б.Бат-Эрдэнэ 79**, **С.Нямжав 57**, **С.Батдэлгэр 44** удаа тус тус оролцсон бол шүүгч **Д.Пунцаг 57** удаа оролцож, **7** удаа даргалж, **18** хэрэг илтгэсэн байна.


Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний захирамж **47**-г гаргаснаас Танхимын тэргүүний “шүүхийн харъяалал тогтоох” захирамж **5**, бусад захирамж **42** байсан байна.

2. Иргэний хэргийн танхим:

Иргэний хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл **52** хэрэг дээр нэмж, хяналтын журмаар иргэний **865**, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан **178**, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулах тухай хүсэлтээр **40**, нийт **1135** хэрэг хүлээн авчээ.

Тайлангийн хугацаанд **822** хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, **35** хэргийг хяналтын журмаар хэлэлцэхээс татгалзаж, иргэний хэргийн харъяалал тогтоолгохоор ирүүлсэн **6** хэргийн харъяаллыг тогтоож, **38** хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулах тухай хүсэлтээр хянан хэлэлцэж, **187** хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, Ерөнхий шүүгчийн дүгнэлтээр **1** хэрэг Нийт шүүгчдийн хуралдаанаар хянагдаж, одоо **46** хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авсан 1135 хэргээс



Иргэний хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт **68** өдөр хуралдаж, **өдөрт** дунджаар **12** хэрэг хэлэлцэн, нийт **860 /4** хэргийг нь захиргааны хэргийн танхимын бүрэлдэхүүн шийдвэрлэсэн/ хэрэг хянан шийдвэрлэжээ.

Хяналтын журмаар хэлэлцэгдсэн иргэний **822** хэргийн **66,2** хувь буюу **544** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хэрэгсэхгүй болгож, **10** хувь буюу **82** хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, **11** хувь буюу **91** хэргийн шийдвэрийг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгож, **12,8** хувь буюу **105** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон байна.


Өөрчлөлт оруулсан **82** шийдвэр, магадлалын **67** хувь буюу **55** нь хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хэрэглэсэн, хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн, **33** хувь буюу **27** нь шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон **105** шийдвэр, магадлалтай хэргээс **88,6** хувь буюу **93** хэргийг шүүхээр дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, **11,4** хувь буюу **12** хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон байна.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан **105** хэргийн **66,6** хувь буюу **70** нь шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, **33,4** хувь буюу **35** нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн байна.

Хяналтын журмаар шүүгч **А.Доржготов 214, Л.Бямбаа 208, Д.Тунгалаг 202**, Танхимын тэргүүн **Б.Ундрах 178**, шүүгч **Ц.Амарсайхан 125** хэрэг тус тус хүлээн авчээ.

Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг




Хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдаанд Иргэний танхимын тэргүүн **Б.Ундрах 781**, шүүгч **А.Доржготов 764**, **Ц.Амарсайхан 755**, **Л.Бямбаа 749**, **Д.Тунгалаг 721** удаа оролцсоноос:

Шүүгч **Ц.Амарсайхан 546**, Танхимын тэргүүн **Б.Ундрах 176**, шүүгч **А.Доржготов 55**, **Л.Бямбаа 23**, **Д.Тунгалаг 15** хуралдааныг тус тус даргалж;

Шүүгч **А.Доржготов 202**, **Л.Бямбаа 194**, **Д.Тунгалаг 185**, Танхимын тэргүүн **Б.Ундрах 169**, шүүгч **Ц.Амарсайхан 106** хэрэг тус тус илтгэжээ.

Иргэний хэргийн танхимын шүүгчдийн 2011 оны бүтэн жилийн ажлын ачаалал



Нийт шүүгчдийн хуралдаанаар иргэний **1** хэргийг Ерөнхий шүүгчийн дүгнэлтээр хянан хэлэлцэж шийдвэрлэжээ.

Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **413** нэхэмжлэгчийн, **431** хариуцагчийн, **6** гуравдагч этгээдийн гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Тус танхим **2011** онд нийт **117** албан бичиг, **50** өргөдөл, гомдол хүлээн авснаас шүүгч **Ц.Амарсайхан** албан бичиг **78**, өргөдөл гомдол **39**, Танхимын тэргүүн **Б.Ундрах** албан бичиг **28**, өргөдөл гомдол **8**, шүүгч **А.Доржготов** албан бичиг **9**, **Л.Бямбаа** албан бичиг **1**, өргөдөл гомдол **2**, **Д.Тунгалаг** албан бичиг **1**-т тус тус хариу өгч, одоо **1** өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй байна.

Хяналтын шатны **эрүүгийн** хэргийн шүүх хуралдаанд:

Шүүгч **Ц.Амарсайхан 184** удаа оролцсоноос **77** удаа даргалж, Танхимын тэргүүн **Б.Ундрах 146** удаа оролцсоноос **35** удаа даргалж, шүүгч **Л.Бямбаа 96**, **А.Доржготов 79**, **Д.Тунгалаг 60** удаа тус тус оролцжээ.

Харин **захиргааны** хэргийн шүүх хуралдаанд:

Шүүгч **Ц.Амарсайхан 78** удаа оролцсоноос **70** удаа даргалж, Танхимын тэргүүн **Б.Ундрах 77** удаа оролцсоноос **2** удаа даргалж, шүүгч **Л.Бямбаа 59** удаа, **Д.Тунгалаг 44** удаа, **А.Доржготов 36** удаа тус тус оролцсон байна.

Иргэний хэргийн танхим 2011 онд Улс төрийн намын бүртгэлийн талаар дараах ажлыг хийжээ. Үүнд:

- “Хөдөлмөрийн үндэсний нам”-ыг;
- “Монголын Ногоон нам”-ын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг;
- “Монголын Ногоон нам”-ыг “Иргэний зориг нам”-д нэгтгэх замаар өөрчлөн байгуулагдах өөрчлөлтийг;
- “Монголын Ногоон нам”, “Иргэний зориг нам”-ын гэрчилгээг хүчингүйд тооцох хүсэлтийг;
- “Монголын Хүний төлөө нам”-ыг тус тус улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан шийдвэр гаргажээ.

Харин,

- “Ардчилсан нам”-ын дүрмийн өөрчлөлтийг;
- “Монгол Ардын хувьсгалт нам”-ыг;
- “Үндэсний Шинэ нам”-ын дүрмийн болон нэрийн өөрчлөлтийг;
- “Монголын Ногоон нам”-ын дүрмийн өөрчлөлтийг;
- “Хамуг Монголын Хөдөлмөрийн нам”-ыг;
- “Хөдөлмөрийн үндэсний нам”-ыг тус тус улсын бүртгэлд бүртгэсэн шийдвэр гаргасан байна.

Түүнчлэн “Монгол Ардын хувьсгалт нам”, “Монгол Үндэсний ардчилсан нам”, “Хамуг Монголын Хөдөлмөрийн нам”, “Хөдөлмөрийн үндэсний нам”-ын гэрчилгээг шинээр олгожээ.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж **689**-г гаргаснаас шүүгчийн “Гомдол хэлэлцүүлэхээс татгалзах тухай” **5**, “Гомдолд гаргаагүйд тооцох тухай” **5**, “Гомдлыг хүлээж авахаас татгалзах тухай” **28**, “Улсын тэмдэгтийн хураамж буцаан олгох тухай” **155** захирамж, Танхимын тэргүүний “Шүүх бүрэлдэхүүн томилох тухай” **475**, “Улсын тэмдэгтийн хураамж буцаан олгох тухай” **10**, “Хэргийн харьяалал тогтоох тухай” **6**, “Хэргийн хугацаа сунгах тухай” **4**, “Гомдол хэлэлцүүлэхээс татгалзах тухай” **1** захирамж тус тус гарчээ.

3.Захиргааны хэргийн танхим:


Захиргааны хэргийн танхим давж заалдах болон хяналтын журмаар өмнөх оны үлдэгдэл давж заалдах журмаар гомдол гаргасан **27**, хяналтын журмаар гомдол гаргасан **14**, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан **6**, бүгд **47** хэрэг дээр нэмж давж заалдах журмаар **136**, хяналтын журмаар **239**, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан **60**, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулах тухай хүсэлтээр **12**, нийт **494** хэрэг хүлээн авчээ.

Давж заалдах журмаар 142 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх байгуулагдсан тул **21** хэргийг тус шүүхэд шийлжүүлж;

Хяналтын журмаар 263 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, одоо **2** хэргийн;

Ерөнхий шүүгчид хянуулахаар ирүүлсэн **66** хэргээс **59** хэрэгт албан бичгээр хариу өгч, одоо **7** хэргийн үлдэгдэлтэй байна.

Давж заалдах болон хяналтын журмаар нийт хүлээн авсан 491 хэргээс



Захиргааны хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт **37** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **7**, давж заалдах шатны шүүх хуралдаан нийт **11** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **13** хэрэг хянан шийдвэрлэжээ.

Захиргааны хэргийн танхимд давж заалдах журмаар ирүүлсэн **163** хэргээс нэг шүүгчид **33**, хяналтын шатны журмаар ирүүлсэн **263** хэргээс нэг шүүгчид **53** хэрэг тус тус ногдож байна.

Хяналтын журмаар хэлэлцэгдсэн захиргааны **252** хэргийн **67,8** хувь буюу **171** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **6,4** хувь буюу **16** хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, **21,1** хувь буюу **53** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянуулахаар ирүүлсэн **4,7** буюу **12** хэргийн хүсэлтийг хангаагүй байна.

Өөрчлөлт оруулсан **16** шийдвэр, магадлалын **37.5** хувь буюу **6** нь хууль буруу хэрэглэсэн, **31.2** хувь буюу **5** нь шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, **31.2** хувь буюу **5** шийдвэр, магадлалд бусад өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон **53** шийдвэр, магадлалтай хэргээс **32,3** хувь буюу **17** хэргийг хэргийг шүүхээр дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, **1.8** хувь буюу **1** хэргийг хэрэгсэхгүй болгож, **58.4** хувь буюу **31** хэргийн шийдвэрийг хэвээр үлдээж, шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон **7.5** хувь буюу **4** хэрэг байна.


Давж заалдах журмаар хэлэлцэгдсэн захиргааны **142** хэргийн **62** хувь буюу **88** хэргийн шийдвэр, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **9.1** хувь буюу **13** хэргийн шийдвэрт өөрчлөлт оруулж, **24.7** хувь буюу **35** хэргийн шийдвэр, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг хүчингүй болгосон, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянуулахаар ирүүлсэн **2,1** хувь буюу **3** хэргийн хүсэлтийг хангаагүй, **2.1** хувь буюу **3** хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхгүйгээр хянаад буцаасан байна.

Өөрчлөлт оруулсан **13** шийдвэрийн **53.8** хувь буюу **7** нь хууль буруу хэрэглэсэн, **46.2** хувь буюу **6** нь нотлох баримтыг буруу үнэлсэн гэсэн үндэслэлээр өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон **35** шийдвэр, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолтой хэргээс **54.3** хувь буюу **19** хэргийг шүүхээр дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, **28.5** хувь буюу **10** нэхэмжлэл болон хэргийг хэрэгсэхгүй болгож, **17.2** хувь буюу **6** хэргийн шийдвэрийг хүчингүй болгож нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн байна.

Шүүгч Ч.Тунгалаг давж заалдах журмаар **33**, хяналтын журмаар **59**, Л.Атарцэцэг давж заалдах журмаар **34**, хяналтын журмаар **56**, П.Цэцгээ давж заалдах журмаар **38**, хяналтын журмаар **54**, Ц.Сумъяа давж заалдах журмаар **34**, хяналтын журмаар **51**, Танхимын тэргүүн О.Зандраа хяналтын журмаар **31**, давж заалдах журмаар **2**, шүүгч Д.Пунцаг давж заалдах журмаар **22**, хяналтын журмаар **18** захиргааны хэрэг тус тус **хүлээн** авчээ. /4 иргэний хэргийг тус танхимын бүрэлдэхүүнээр шийдвэрлэсэн./


Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг



Давж заалдах шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд шүүгч Л.Атарцэцэг **50**, Ц.Сумъяа **43**, Ч.Тунгалаг **38**, Д.Пунцаг **23**, П.Цэцгээ **16** удаа тус тус **оролцож**;

Шүүгч Ч.Тунгалаг **38**, П.Цэцгээ **36**, Ц.Сумъяа **34**, Д.Пунцаг **25**, Л.Атарцэцэг **22** захиргааны хэргийн шүүх хуралдааныг тус тус **даргалж**;


Шүүгч П.Цэцгээ 33, Ц.Сумъяа 32, Л.Атарцэцэг 30, Ч.Тунгалаг 30, Д.Пунцаг 17 хэрэг тус тус илтгэсэн байна.



Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд шүүгч Ч.Тунгалаг 114, П.Цэцгээ 100, Ц.Сумъяа 80, Л.Атарцэцэг 55, Д.Пунцаг 37, удаа тус тус **оролцож**;

Танхимын тэргүүн О.Зандраа 214, Ц.Сумъяа 21, П.Цэцгээ 16, Л.Атарцэцэг 8, Д.Пунцаг 7, Ч.Тунгалаг 5, хэргийн шүүх хуралдааныг тус тус **даргалж**;

Шүүгч Ч.Тунгалаг 55, Л.Атарцэцэг 54, П.Цэцгээ 51, Ц.Сумъяа 48, Танхимын тэргүүн О.Зандраа 26, шүүгч Д.Пунцаг 18 хэрэг тус тус **илтгэсэн** байна.



Давж заалдах болон хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн 40.4 хувь буюу 200 нь нэхэмжлэгчийн, 22.8 хувь буюу 113 нь хариуцагчийн, 13.6 хувь буюу 67 нь гуравдагч этгээд, 14.7 хувь буюу 73 нь хэргийн оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, 8.5 хувь буюу 41 нь хэргийн оролцогчийн өмгөөлөгчийн гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Тус танхим 2011 онд нийт 25 албан бичиг, 7 өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн О.Зандраа 4 албан бичиг, 4 өргөдөл гомдол, шүүгч Ч.Тунгалаг 5 албан бичиг, 1 өргөдөл гомдол, Л.Атарцэцэг 4 албан бичиг, 1 өргөдөл гомдол, Ц.Сумъяа 4 албан бичиг, 1 өргөдөл гомдол, П.Цэцгээ 5 албан бичгийг тус тус хянан шийдвэрлэж, одоо 3 албан бичгийн үлдэгдэлтэй байна.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд:

Танхимын тэргүүн О.Зандраа 274 удаа оролцсоноос 116 удаа даргалж, шүүгч Ц.Сумъяа 137, П.Цэцгээ 121, Ч.Тунгалаг 102, Л.Атарцэцэг 76 удаа тус тус оролцжээ.

Харин **хяналтын шатны иргэний** хэргийн шүүх хуралдаанд:

Танхимын тэргүүн О.Зандраа 69 удаа оролцсоноос 44 удаа даргалж, 1 хэргийг илтгэж, шүүгч Ц.Сумъяа 96 удаа оролцсоноос, 1 хэрэг илтгэж, Ч.Тунгалаг 81 удаа оролцсоноос, 1 хэрэг илтгэж, Л.Атарцэцэг 51 удаа оролцсоноос, 1 хэрэг илтгэж, П.Цэцгээ 78 удаа оролцожээ.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол **527** гаргаснаас “Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулах тухай” **15**, “Шүүх хуралдааныг хойшлуулах тухай” **41** шүүхийн тогтоол, “Гомдол хэлэлцүүлэхээс татгалзах тухай” **3**, “Гомдол гаргаагүйд тооцох тухай” **5**, “Улсын тэмдэгтийн хураамж буцаах тухай” **14** шүүгчийн захирамж, Танхимын тэргүүний “Шүүх бүрэлдэхүүн томилох тухай” **420**, бусад **29** захирамж тус тус гаргасан байна.

Хоёр. Мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагааны талаар

Тайлангийн хугацаанд танхимуудаас дараах зөвлөмжийг боловсруулан гаргаж, нийт шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангаснаас гадна “**Дээд шүүхийн мэдээлэл**” сэтгүүлд хэвлүүлээ. Тухайлбал:

- Эрүүгийн хэргийн танхим “**Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 338, 339, 340 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхэд шүүхээс анхаарах зарим асуудал**” сэдэвт зөвлөмж;
- Захиргааны хэргийн танхим “**Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн зарим зүйл заалтыг зөв хэрэглэх тухай**” сэдэвт зөвлөмжийг;

Улсын Дээд Шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын шүүгчид **Өвөрхангай, Хөвсгөл, Говь-Алтай, Дундговь, Говьсүмбэр** аймгийн шүүхийн ажилтай танилцах, мэргэжлийн удирдлагаар ханган, холбогдох сургалтыг газар дээр нь зохион байгууллаа.

Нийт шүүгчдийн хуралдаанаар дээрхи шүүхүүдийн ажилтай танилцан мэргэжлийн удирдлагаар хангасан тухай асуудлыг хэлэлцэж, **тэмдэглэл** гарган холбогдох шүүхүүдэд нь хүргүүлээ.

Гурав. Тамгын газрын ажлын талаар

Тамгын газар нь Шүүхийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гарсан дүрэм, журам, заавар, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх, нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэх талаар анхааран ажиллаж иржээ.

Авлигын эсрэг хууль, “Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам”-д заасны дагуу шүүгч, захиргааны албан хаагчдаас “**Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг**”-ийг **2010** оны байдлаар гаргуулан авч, **17** шүүгчийн материалыг “Авлигатай тэмцэх газар”-т хүргүүлж, захиргааны албан хаагч **1** хүний материалыг Шүүхийн Ерөнхий зөвлөлд, **47** хүний материалыг тамгын газарт зохих журмын дагуу хадгалж байна.

Түүнчлэн “**Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан**”-г шинэчилсэн програмын дагуу гаргаж, Төрийн албаны зөвлөлд хугацаанд нь хүргүүлээ.

Тамгын газрын даргын зөвлөл **6** удаа хуралдаж, Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт **20** гаруй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэжээ.

Тамгын газрын дарга хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт **90** тушаал гаргасан байна.

Одоо тамгын газрын харъяа албадын ажлын талаар товч дурдъя.

1. Ерөнхий шүүгчийн ажлын алба.

Тус алба нь тайлангийн хугацаанд **17** албан бичиг, **170** өргөдөл, гомдол, хүлээн авч цаг тухайд нь хариуг нь өгсөн бөгөөд одоо **1** албан бичиг, **9** өргөдөл гомдлын үлдэгдэлтэй байна.

Ерөнхий шүүгчид гаргасан гомдлыг үндэслэн Ерөнхий шүүгчийн ажлын алба эрүүгийн **73**, иргэний **200**, захиргааны **66**, нийт **339** хэрэг хүлээн авч Ерөнхий шүүгчид танилцуулснаас Ерөнхий шүүгч эрүүгийн **1**, иргэний **1** хэргийн тогтоолд хууль зөрчсөн үндэслэлээр дүгнэлт бичиж, Нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, дүгнэлт бичигдээгүй **337** хэрэгт тус алба хариу өгчээ. Өмнөх онтой харьцуулахад эрүүгийн хэрэг **22**-оор өсч, иргэний хэрэг **47**-оор, захиргааны хэрэг **16**-аар тус тус буурсан байна.

Түүнчлэн шүүгч **Т.Уранцэцэг** хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд **111** удаа, иргэний хэргийн шүүх хуралдаан **86** удаа, захиргааны хэргийн шүүх хуралдаанд **12** удаа, нийт **209** удаа оролцжээ. Мөн Ерөнхий шүүгчид хандаж гомдол гаргасан эрүүгийн **36**, иргэний **11**, захиргааны **7**, нийт **54** хэргийг хүлээн авч, зохих хариуг өгчээ. Дээрхээс гадна хэргийн оролцогч болон бусад иргэн, хуулийн этгээдэд **87** албан бичгийг боловсруулж, Ерөнхий шүүгчид танилцуулан хүргүүлжээ.

Тайлангийн хугацаанд ажлын албаны дарга, бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах зааварлагчийг байлцуулан хэргийн оролцогчид болон иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөгч **218** хүнийг сар бүрийн **4** дүгээр **7** хоногийн **пүрэв** гаригт хүлээн авч уулзаж, тэдний санал, хүсэлтийг сонсож, Ерөнхий шүүгчид тухай бүрт нь танилцуулж, зохих хариуг өгч шийдвэрлэжээ.

Мөн хугацаанд тус алба нь Ерөнхий шүүгчид хандаж гаргасан гомдлын дагуу эрүү, иргэн, захиргааны хэргийг хянах явцад шүүх, шүүгчдийн болон захиргааны ажилтнуудын гаргасан алдаа, зөрчлийн талаар тусгайлан бүртгэл хөтөлж, давхардсан тоогоор **23** шүүгч, **82** захиргааны ажилтанд энэ талаар мэдэгдэж, зөвлөмж өгч ажиллажээ.

Түүнчлэн Архангай, **Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Хэнтий** аймгийн шүүхийн шүүгч, ажилтнуудад Улсын Дээд шүүхээс хийсэн ажил болон Ерөнхий шүүгчээс өгсөн үүрэг даалгаварын талаар мэдээлэл хийжээ.

Цагаатгалын үнэмлэх олгох талаар хэлмэгдэгчдийн төрөл садан болон Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссуудаар дамжуулан **56** өргөдөл, хүсэлтийг хүлээн авч **“Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль”**-д заасны дагуу Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2006 оны 11 дүгээр захирамжийг баримтлан нийтдээ **45** ширхэг үнэмлэх олгосноос **30** үнэмлэхийг /**16968-16997** хүртэлх дугаартай/ хүсэлт гаргагч нарт шинээр олгож, хаяж, үрэгдүүлсэн **15** үнэмлэхийг нөхөн бичиж өгсөн байна.

2. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба.

Тус алба нь шүүхийн шүүн таслах болон бусад үйл ажиллагаа, мөн Шүүхийн Ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны талаар давхардсан тоогоор сонинд **479**, телевизэд **294**, радиод **75**, вэб сайтуудад **509** мэдээ, мэдээлэл бэлтгэн нийтлүүлж, нэвтрүүлжээ. Мөн телевизүүдийн урсдаг мэдээгээр давхардсан тоогоор **185** мэдээг олон нийтэд хүргэсэн байна. Үүний заримаас дурьдвал:

Телевизийн нэвтрүүлгийн хувьд:

Монголын үндэсний олон нийтийн телевизтэй хамтран **“Эрх зүйн хөтөч”** телесэтгүүлд:

- анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шүүгч нарын 10 теле ярилцлага;
- гэр бүлийн, хөдөлмөрийн эрх зүй зэрэг сэдвээр шүүх хуралдааны 17 жүжигчилсэн телезохиомж;

Радиогийн нэвтрүүлгийн хувьд:

- Монголын үндэсний олон нийтийн радиогийн хууль эрх зүйн **“Соёмбо”** нэвтрүүлгээр “Иргэний болон захиргааны эрх зүйн маргааны шалтгаан, нөхцөл, анхаарах зарим асуудлууд” сэдвээр;

Сонин, нийтлэлийн хувьд:

- Шүүхийг олон нийтэд сурталчлах, шүүн таслах ажиллагааны хууль зүйн үндсийн талаар шүүгч, шүүхийн ажилтан **29** хүний ярилцлага;
- Тодорхой хэрэг маргаан, түүнийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэртэй холбоотой **26** нийтлэл, өгүүллэг;
- **2011** оны **1, 2, 3** дугаар улирлын шүүн таслах ажиллагааны мэдээ зэргийг тус тус өдөр тутмын болон бусад сонинд нийлүүлсэн байна.

Хэвлэлийн бага хурлын хувьд:

- “Нийслэл, дүүргийн шүүхийн шүүгчдийн ажлын ачаалал, шүүн таслах ажлын дүн” болон эрүү, иргэн, захиргааны хэргийн талаар 6 удаа;
- “Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагааны онцлог, ил тод нээлттэй байдал, түгээмэл шийдвэрлэгддэг зарим төрлийн хэргүүд”-ийн талаар;
- “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх”-ийн талаар;
- “Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг”-ийн талаар;
- “Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг”-ийн талаар;
- “Хэрэгсэхгүй болгож цагаатгасан эрүүгийн хэргүүд”-ийн талаар хэвлэлийн бага хурлыг тус тус зохион байгуулжээ.

Эдгээрээс гадна Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх ажлын хүрээнд хууль эрх зүйн чиглэлээр дагнан мэргэшсэн сэтгүүлчдэд **“Шүүхийг сурвалжлах нь”** сэдэвт цуврал сургалтыг сар бүр зохион байгуулж хэвшлээ. Тухайлбал,

- “Иргэний эрх зүйн практик сургалт”;
- “Эрүүгийн эрх зүйн практик сургалт”;
- “Захиргааны хэргийн практик сургалт”;
- Нийслэлийн Хан-Уул дүүргийн болон Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхүүдийн үйл ажиллагаатай танилцах-сургалтуудыг тус тус зохион байгуулж, энэ чиглэлийн зарим шүүхийн шүүгч, захиргааны ажилтнууд хичээл заалаа.

Дээрх цуврал сургалт нь шүүх, хэвлэл мэдээллийн байгууллагын хооронд эргэх холбоо тогтоох, шүүхийн байгууллагын талаар үнэн, зөв, бодит мэдээллийг олон нийтэд түгээх, төлөвшүүлэхэд ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

Анхан, давж заалдах болон дагнасан шүүхүүдээс **2** сар тутамд шинэ мэдээ, мэдээллийг хүлээн авч Ерөнхий шүүгчид танилцуулан, нэгтгэж, шүүхийн нэгдсэн мэдээллийн системийн вэб сайт www.judgeinfo.mn-д байрлуулж, сонинд нийтлүүлж, телевизийн урсдаг мэдээгээр олон нийтэд дамжуулсан байна.

Улсын Дээд шүүхэд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргаж ирүүлсэн эрүү, иргэн, захиргааны хэргийн талаар эрүүгийн **345**, иргэний **386**, захиргааны **532** оролцогчдод утсаар болон биечлэн лавлагаа өгч, эрх зүйн мэдээллээр ханган ажиллажээ.

3. Шүүхийн судалгааны төв.

Судалгааны төв нь шүүн таслах ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх, хуулийг нэг мөр ойлгон, зөв хэрэглэж буй талаар дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга замыг тодорхойлох, хуулийн тайлбар гаргахад судалгаа хийх, төсөл боловсруулах зэрэгт түлхүү анхааран ажиллажээ.

“Дээд шүүхийн мэдээлэл”, “Монголын төр, эрх зүй”, сэтгүүлийг эрхлэн гаргаж, олон нийтийн хүртээл болгож байна. Мөн зарим албатай хамтран “Монгол Улсын шүүхийн 2010 оны жилийн тайлан”-г эмхтгэн хэвлүүллээ.

Тайлангийн хугацаанд тус төв тоон болон чанарын **54** судалгаа хийснээс чанарын судалгаа **14** буюу **25** хувийг эзэлж байна. Байгууллага дотоодын захиалгаар хууль тайлбарлах, зөвлөмж гаргах, мөн тухайн үеийн ажлын шаардлагын дагуу Ерөнхий шүүгчид-**1**, Шүүхийн Ерөнхий зөвлөлд-**1**, Эрүүгийн хэргийн танхимд-**5**, Иргэний хэргийн танхимд-**6**, Захиргааны хэргийн танхимд-**5**, Хэвлэл мэдээллийн албанд-**6** нийт тоон болон чанарын **24** судалгааг хийж гүйцэтгэжээ. Тухайлбал:

- Эрүүгийн хэргийн танхимын захиалгаар “Прокурор хохирогчийн эрхийг хамгаалах талаарх Герман, Австрали улсуудын Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудад хийсэн шинжилгээ”;
- Иргэний хэргийн танхимын захиалгаар “2009-2011 онд хяналтын шатны шүүхээр хэлцэлтэй холбоотой маргааны шийдвэр, магадлал өөрчлөгдсөн, хүчингүй болсон шалтгаан”;
- Захиргааны хэргийн танхимын захиалгаар “2009-2011 онд давж заалдах болон хяналтын шатны шүүхээр “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн дагуу шийдвэрлэгдсэн хэргийн судалгаа” зэрэг болно.

Мөн зарим төрийн болон төрийн бус байгууллагын захиалга, хүсэлтийн дагуу тоон болон чанарын **22** судалгаа хийсэн байна. Тухайлбал:

- Ерөнхийлөгчийн Тамгын газрын захиалгаар “2009-2010 онд шийдвэрлэгдсэн эрүү, иргэн, захиргааны хэргийн талаарх судалгаа”;
- Хууль зүй, Дотоод хэргийн яамны захиалгаар “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүний нэр төр, алдар хүндийг гутаасан хэргийн талаарх судалгаа”;
- Хүний эрхийн комиссын захиалгаар “2001-2010 онуудад анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхүүдээр цаазаар авах ял шийтгүүлэгсдийн судалгаа”;
- АНУ-ын Азийн сангийн захиалгаар “Хүн худалдаалах, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн практик” зэрэг болно.

Түүнчлэн Шүүхийн багц хуулийн ажлын хэсэгтэй хамтран уг хуулиудын шинэчилсэн найруулгад, Эрүүгийн хэргийн танхимтай хамтран “Эрүүгийн хууль”, “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”-ийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд судалгаа хийж, санал өгч ажиллажээ.

Шүүн таслах ажиллагааны статистик, тоон мэдээллийг 2011 оны эхний улиралуудын болон хагас, бүтэн жилийн мэдээг нэгтгэн гаргаж, хянан холбогдох албан тушаалтан, байгууллагуудад хүргэх ажлыг зохион байгуулсан байна.

Түүнчлэн шүүхийн нэгдсэн санг бүрдүүлэх, баяжуулах, хяналт тавих ажлыг холбогдох журмын дагуу гүйцэтгэжээ. Тухайлбал:

- Ерөнхийлөгчийн зарлиг **50**;
- Шинээр батлагдсан хууль **176**, нэмэлт, өөрчлөлт орсон хууль **81**, хүчингүй болсон хууль **5**;
- Улсын Их Хурлын шинээр баталсан тогтоол **57**, өөрчлөлт оруулсан **5**, хүчингүй болсон тогтоол **2**;
- Засгийн газрын шинээр баталсан тогтоол **4**;
- Тойм **9**, зөвлөмж **3**-ыг тус тус шүүхийн мэдээллийн нэгдсэн санд оруулжээ.

Мөн холбогдох судалгаа, статистик мэдээ, мэдээлэл, баримтын талаар шүүхийн ажилтан болон зарим хуульч нийт **55** хүнд лавлагаа өгсөн байна.

Мөн тус төв “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл”, “Архидан согтуурахтай тэмцэх орон тооны бус зөвлөл”, “Хүүхдийг эрсдээс хамгаалах үндэсний зөвлөл”, НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр хуулийн байгууллагад хэрэгжиж байгаа “Хүүхдэд ээлтэй хууль зүйн орчин” зэрэг төслийн байгууллагатай хамтран ажиллаж тодорхой зарим үр дүнд хүрчээ.

4. Санхүү, хангамж, үйлчилгээний алба.

Улсын Дээд шүүх 2011 онд урсгал зардалд 1 тэрбум 025,5 сая төгрөг, улсын төсвөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалтад 188.8 сая төгрөг, нийт 1 тэрбум 214,3 сая төгрөгийн төсөв батлагдаж, батлагдсан төсвийг зардлын ангилал тус бүрээр зохих журмын дагуу зарцуулж, санхүүгийн мэдээ, тайланг холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь гарган өгч, ямар нэгэн байгууллага, хувь хүмүүст өр авлага гаргалгүй ажиллажээ.

Шүүгч, ажилтан, ахмадын зөвлөлийн гишүүн 5 хүнд 2 сая төгрөгийн буцалтгүй тусламж, эмчилгээний зардал 2 хүнд 200 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 2 хүнд 44,7 сая төгрөг нийт 46,9 сая төгрөгийг тус тус олгожээ.

2011 оны ээлжийн амралтаар өөрийн буюу эхнэр, нөхрийн төрсөн нутагт очиж амарсан 5 ажилтанд унааны зардалд 288 мянган төгрөгийг тооцон олгосон байна.

Түүнчлэн 2011 онд үр бүтээл, санаачлага, идэвх, зүтгэл гарган ажилласан тус шүүхийн шүүгч, ажилтнууд болон бусад байгууллагын ажилтан нийт 85 хүнийг 22,9 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа.

Төсвийн хөрөнгө оруулалтын зардлаар батлагдсан мөнгөн хөрөнгөөр Улсын Дээд шүүхийн шинээр баригдах барилгын эскиз зураг болон ажлын зургийг 70 сая төгрөгөөр гүйцэтгүүллээ.

Мөн албан ажлын шаардлагаар шүүгч, ажилтнуудад зайлшгүй шаардлагатай байгаа автомашины дулаан граж 7-ийг 84 сая төгрөгөөр, “Ниссан Урбан” маркийн микроавтобусыг 52 сая төгрөгөөр, түүнчлэн “Жи мобайл”-н гар утас 20-ийг 2,5 сая төгрөгөөр, дижитал зургийн аппарат 1-ийг 1,7 сая төгрөгөөр, хувилагч машин 1-ийг 7,3 сая төгрөгөөр, шүүх хуралдааны танхимд шүүгчийн сандал 2-ыг 1,9 сая төгрөгөөр, шүүгчийн өрөөний тавилга 2 комыг 14,8 сая төгрөгөөр, байрлал тодорхойлогч GPS 2-ыг 960 мянган төгрөгөөр, файлын шүүгээ, сейф 810 мянган төгрөгөөр, халуун, хүйтэн үлээгч 8-ийг 8,5 сая төгрөгөөр, зөөврийн компьютер 6-г 8,1 сая төгрөгөөр, хивс угаагч машин 1-г 1,4 сая төгрөгөөр, тоос сорогч 5-ыг 1,1 сая төгрөгөөр, өнгөт принтер 1-ийг 780 мянган төгрөгөөр, проектор, проекторын дэлгэцийг 4,2 сая төгрөгөөр, камерийн бичлэг хадгалах төхөөрөмж, файл сервер, вэб сайт, мэдээллийн аюулгүй байдал түүний хяналтын системийн програмыг 12,2 сая төгрөгөөр, нийт 202,7 сая төгрөгөөр худалдан авчээ.

Төрийн өмчийн хорооны шийдвэрээр Улсын Дээд шүүхийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 14 нэрийн 25,804,434 төгрөгийн үнэ бүхий тавилга, эд хогшил, автомашины зарим аймаг, нийслэлийн шүүхэд шилжүүлж, 8 нэрийн 8,459,548 төгрөгийн үнэ бүхий техник, тоног төхөөрөмжийг акталлаа.

Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллого явуулах тухай” 167 дугаар тогтоолын дагуу эд хөрөнгийн тооллогыг явуулж:

- 372,8 сая төгрөгийн конторын барилга;
- 119,6 сая төгрөгийн 2 орон сууц;
- 365,6 сая төгрөгийн 9 автомашин;
- 383,9 сая төгрөгийн тавилга, эд хогшил;
- 84,4 сая төгрөгийн бараа материал;
- 2 сая төгрөгийн санхүү, бичиг хэрэг, вэб сайтын программ хангамж;
- 2,8 сая төгрөгийн номын фонд
- 182,8 сая төгрөгийн гаднах инженерийн шугам, тохижилт, нийт 1 тэрбум 466,3 сая төгрөгийн эд хөрөнгө тоологджээ.

Тооллогын дүнд дутсан, алга болж үрэгдсэн хөрөнгө гараагүй болно.

2012 оны төсөвт урсгал зардалд 1 тэрбум 598 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 193 сая төгрөг, нийт 1 тэрбум 791 сая төгрөг батлагдаж, 2011 оныхтай харьцуулахад нийт төсөв 47,5 хувиар буюу 576,7 сая төгрөгөөр нэмэгдлээ.

5. Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын алба.

2009 онд ХЗДХЯ, Үндэсний Архивын Ерөнхий газраас байгуулагдсан комисс “Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг”-ийн дагуу ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллаа. Тухайлбал,

- Байгууллагын хэмжээний бүх компьютерийг вирусын эсрэг програмаар хангах ажлыг зохион байгуулах;

- Өндөр хурдны интернэтэд холбох, түүнийг ашиглах;
- Баримт бичиг боловсруулах, баталгаажуулах, бүртгэлжүүлэх, хадгалах ажлыг шинэчилсэн стандартын дагуу гүйцэтгэх, түүнд ашиглагдах програмыг хэрэглэх;
- Тамгын газрын үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Бүрэн деффиринциал буюу хэрэглэгч, байгууллага шууд мэдээлэл солилцох, тоон технологийн шинэчилсэн хувилбараар ажиллах горим бүхий вэб сайт бүтээж ажиллуулсан зэрэг болно.

Тайлангийн хугацаанд тус алба нь нийт **392** өргөдөл гомдол, **421** албан бичиг, **4103** хавтаст хэрэг хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэн, бүртгэл хяналтын карт нээж, уг албан бичгүүдийг Ерөнхий шүүгчид танилцуулсны дагуу шүүгч, ажилтнуудад хувиарлан өгч шийдвэрлүүлсэнээс гадна **3477** албан бичигт дугаар өгч холбогдох шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад явуулжээ. Өмнөх онтой харьцуулахад хүлээн авсан өргөдөл гомдол **29**-өөр, албан бичиг **324**-өөр, явуулсан бичиг **778**-аар тус тус буурч, хавтаст хэрэг **242**-оор өсчээ.

Мөн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Нийт шүүгчдийн хуралдааны зохион байгуулалтын асуудал хариуцсан ахлах шинжээч **Д.Хулан** Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн, **Ц.Сайхантуяа** Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн, **Ч.Цэнд** Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчээр тус тус томилогдож, **Н.Дамдинсүрэнг** Захиргааны хэргийн танхимын тэргүүний туслах-ахлах шинжээчийн, **Б.Ундрааг** Иргэний хэргийн танхимын тэргүүний туслах-ахлах шинжээчийн албан тушаалд томилон дэвшүүлэн ажиллуулж байна.

Түүнчлэн **Х.Идэр**, **О.Батсүх**, **Н.Гэрэлтуяа** **Т.Жавхлантөгс** нарыг Шүүгчийн туслах-шинжээчийн, **Э.Амин-Эрдэнийг** Эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагааны судалгаа хариуцсан шинжээчийн, **Ш.Гандансүрэнг** Тамгын газрын даргын туслах-шинжээчийн, **Ч.Даваасүрэнг** Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах мэргэжилтний, **Б.Дүүрэнжаргалыг** Мэдээлэл, лавлагааны ажил хариуцсан мэргэжилтэний албан тушаалд, **Л.Батжаргал**, **Э.Цог-Эрдэнэ**, **Б.Жумдаандорж** нарыг жолоочийн, **Ц.Пагамыг** үйлчлэгчийн ажилд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн Тамгын газрын даргын тушаалаар тус тус томилжээ.

Тайлангийн хугацаанд:

- Иргэний хэргийн танхимын тэргүүний туслах-ахлах шинжээч **И.Амартөгс**, Захиргааны хэргийн танхимын тэргүүний туслах-ахлах шинжээч **Ч.Цэнд**, Эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагааны судалгаа хариуцсан шинжээч **Ц.Баярмаа**, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны судалгаа хариуцсан шинжээч **Ш.Даваадулам**, Хууль, тогтоомжийн системчлэл хариуцсан ахлах мэргэжилтэн **Ч.Жаргалсайхан** нарын **5** хүний **зэрэг дэвийг**;
- Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч **Г.Билгүүн**, Захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч **Н.Дамдинсүрэн**, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны судалгаа хариуцсан шинжээч **Н.Мөнгөнцэцэг** нарын **3** хүний **үндсэн цалингийн шатлалыг**;
- Компьютерийн программ хангамжийн асуудал хариуцсан референт **Э.Баярбаатарт** Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, Санхүү, Хангамж хариуцсан референт-Ерөнхий нягтлан бодогч **А.Эрдэнэцэцэгт** Мэргэшсэн нягтлан бодогчийн зэргийн **нэмэгдлийг** тус тус шинээр болон нэмэгдүүлэн олгожээ.

“**Билгийн тооллын хаврын тэргүүн сар - Цагаан сарын баяр**”, “Хүүхдийн баяр”, “**Ахмадын баярын өдөр**” зэрэг тэмдэглэлт баяруудыг тохиолдуулсан арга хэмжээг тухай бүр зохион байгуулж, ойн баяр болон тэмдэглэлт өдрүүдэд Улсын Дээд шүүх дээр сахилга, хариуцлага, дэг журам, сонор сэрэмжийг өндөржүүлэх зорилгоор **5** удаагийн тушаалаар **9** ажилтныг хариуцлагатай эргүүлээр томилон ажиллуулжээ.

Тайлангийн хугацаанд **11** ажилтан төрийн өөр ажил, албан тушаалд дэвшин ажиллах болсон, өндөр насны тэтгэвэрт гарсан, өөрөө хүсэлт гаргасан зэрэг шалтгааны улмаас төрийн албанаас чөлөөлөгдөж, **1** ажилтанд хүүхэд асрах чөлөө, **1** ажилтанд гадаадад суралцахтай нь холбогдуулан түр чөлөөг тус тус олгожээ.

Шүүгч, ажилтнуудын гэр бүлээс их, дээд сургуульд 2011-2012 оны хичээлийн жилд суралцаж байгаа нийт **8** оюутны “Сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлэх тухай” гэрээг Сургалтын төрийн сантай байгуулж, төлбөрийг нь төлжээ.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Нийслэлийн шүүхийн нэрэмжит 2011 оны “**Шилжин явах цом**”-ын болон Хуулийн төв байгууллагуудын дунд зохион байгуулагддаг “**Шилжин явах цом**”-ын төлөө спортын 5 төрөлт тэмцээнүүдэд Улсын Дээд шүүхийн баг тамирчид амжилттай оролцож, багийн нийлбэр дүнгээр **2** дугаар байрт шалгарлаа.

Дөрөв. Гадаад арга хэмжээний талаар

Шүүхийн гадаад харилцаа жилээс жилд өргөжиж, шүүгч, ажилтнууд гадаад сургалтад хамрагдах, дэлхийн болон олон улсын, тивийн, бүсийн чуулга уулзалт, эрдэм шинжилгээний бага хуралд оролцох, шүүн таслах ажиллагааны талаарх гадаад улсын туршлага судлах ажил нэмэгдэж байна. Тухайлбал,

- Шүүгч С.Нямжав, Б.Бат-Эрдэнэ, Булган аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Ё.Бямбацэрэн нар 2011 оны 3 дугаар сарын 13-16-ний өдрүүдэд Индонези Улсын Жакарта хотноо зохион байгуулагдсан **“Нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст шүүхийн үйл ажиллагааг хүртээмжтэй болгох нь”** сэдэвт олон улсын бага хуралд;
- Иргэний хэргийн танхимын тэргүүн Б.Ундрах, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч Э.Золзаяа нар 2011 оны 5 дугаар сарын 2-6-ний өдрүүдэд АНУ-ын Вашингтон хотноо Дэлхийн оюуны өмчийн газраас зохион байгуулагдсан **“Шүүгчдийн оюуны өмчийн эрхийг хамгаалах”** сэдэвт чуулга уулзалтад;
- Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ц.Зориг, Тамгын газрын дарга Д.Эрдэнэчулуун, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч Х.Батсүрэн нарын төлөөлөгчид 2011 оны 6 дугаар сарын 12-16-ний өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотноо зохион байгуулагдсан **“Ази, Номхон далайн орнуудын Ерөнхий шүүгчдийн 14 дүгээр бага хурал”**-д;
- Шүүгч Б.Бат-Эрдэнэ тэргүүтэй нийслэлийн төвийн 6 дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч нар 2011 оны 6 дугаар сарын 27-ноос 7 дугаар сарын 1-ний өдрүүдэд Сингапур улсад **“Авилгын эсрэг тэмцэх, энэ төрлийн гэмт хэргийг таслан шийдвэрлэх нь”** сэдэвт сургалтад;
- Шүүгч П.Цэцгээ тэргүүтэй зарим анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, тамгын албаны дарга нийт **25** хүн 2011 оны 7 дугаар сарын 3-16-ний өдрүүдэд БНХАУ-ын Ардын Дээд шүүхийн дэргэдэх “Шүүгчийн сургалтын төв”-д зохион байгуулагдсан **“БНХАУ-ын шүүхийн тогтолцоо, шүүгчийн ёс зүй, хэргийн хөдөлгөөний менежмент”** сэдэвт 14 хоногийн сургалтад;
- Шүүгч Л.Атарцэцэг С.Нямжав тэргүүтэй зарим давж заалдах шатны Ерөнхий шүүгч, шүүгч нар 2011 оны 9 дүгээр сарын 9-23-ний өдрүүдэд Тайваны “Шүүгчдийн давтан сургалтын төв”-өөс зохион байгуулсан **“Тайваны шүүхийн тогтолцоо, бүтэц зохион байгуулалт, харилцан туршлага солилцох нь”** сэдэвт 14 хоногийн сургалтад;
- Ерөнхий шүүгч Ц.Зориг, Нийслэлийн шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Б.Батцэрэн, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн Шүүхийн хүний нөөцийн тасгийн дарга Б.Энхбаатар нар 2011 оны 10 дугаар сарын 3-8-ний өдрүүдэд Тайваны шүүх эрх мэдлийн байгууллагуудад албан ёсны айлчлал хийж;
- Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт орох гэж байгаатай холбогдуулан Тамгын газрын дарга Д.Эрдэнэчулуун, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Ц.Цогт, шүүгч М.Батсуурь нар 2011 оны 11 дүгээр сарын 10-17-ний өдрүүдэд Канад Улсын Төрийн албаны комиссын үйл ажиллагаатай тахилцах айлчлал хийж;
- Ерөнхий шүүгч Ц.Зориг, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн ахлах-референт Н.Долгорсүрэн нар 2011 оны 12 дугаар сарын 5-15-ны өдрүүдэд БНЭУ-ын **Лакнау** хотноо зохион байгуулагдсан **“Дэлхийн Ерөнхий шүүгчдийн 12 дугаар бага хурал”**-д тус тус амжилттай оролцжээ.

Түүнчлэн гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд:

- Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг, Монгол Улсын Дээд шүүх, Монголын Өмгөөлөгчдийн Холбооноос хамтран хэрэгжүүлж буй **“Иргэний болон гэр бүлийн хэрэгт эвлэрүүлэн зуучлах тогтолцоог бий болгох”** төслийн Япон дахь зөвлөх багийн ахлагч профессор Инаба Казуто, гишүүн өмгөөлөгч Уэно Сецуко, мэргэжилтэн Исой Миха нар тус төслийн ээлжит 8 дахь удаагийн сургалт-уулзалтыг 2011 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Улсын Дээд шүүх дээр зохион байгууллаа.
- ХБНГУ-ын Хессен мужийн Ерөнхий сайдын орлогч бөгөөд Хууль зүй, интеграци ба Европын асуудал эрхэлсэн **сайд Иорг Увэ Хаан** тэргүүтэй төлөөлөгчдийг 2011 оны 7 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч хүлээн авч уулзлаа. Уулзалтын үеэр Монгол Улсад шүүхийн мониторингийн төслийг хэрэгжүүлэх, ялангуяа иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны нэгдсэн стандартыг бий болгохуйц программ хангамжийг ашиглах асуудлаар ярилцлаа. Энэ үеэр дээрх төслийн зөвлөх хатагтай Вебер Хассемер, ноён Вернер Эрбрехт нарыг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн “Хүндэт тэмдэг”-ээр шагналаа.
- Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн урилгаар Олон Улсын Эрүүгийн шүүхийн Ерөнхийлөгч **ноён Сан Хюун Сон** 2011 оны 7 дугаар сарын 27-30-ны өдрүүдэд Монгол

Улсад албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын үеэр хоёр шүүхийн хамтын ажиллагааг бүхий л талаар өргөжүүлэх, харилцан туршлага судлах, үндэсний хууль тогтоомжоо Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд нийцүүлэн өөрчлөх, олон нийтийг хамарсан хэргийг хэрхэн шийдвэрлэдэг талаар туршлага судлах, энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх зэрэг асуудлуудыг хөндөн ярилцлаа.

- Финланд Улсын Захиргааны хэргийн Дээд шүүхийн Ерөнхийлөгч **Пекка Халлбергийг** 2011 оны 9 дүгээр сарын 02-ны өдөр Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч хүлээн авч уулзаж, хоёр орны шүүхүүдийн хамтын ажиллагааг бүхий л талаар хөгжүүлэх, шүүгч, зарим ажилтнуудыг сургалтад хамруулах, Захиргааны хэргийн Дээд шүүхүүдийн олон улсын холбоонд Монгол Улсын Захиргааны хэргийн шүүх элсэн орох, зарим төрлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар туршлага солилцох зэрэг асуудлуудаар харилцан санал солилцов.
- Монгол-Түвдийн хорооны дарга **Ло Юэн Шао** тэргүүтэй 10 шүүгч 2011 оны 9 дүгээр сарын 04-11-ний өдрүүдэд Монгол Улсын шүүхийн тогтолцоо, бүтэц зохион байгуулалт болон зарим орон нутгийн шүүхийн үйл ажиллагаатай танилцлаа. Энэ үеэр шүүгчдийг Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч хүлээн авч уулзан хоёр талын зохион байгуулж буй шүүгчдийн сургалт, цаашдын хамтын ажиллагааны талаар ярилцлаа.
- ХБНГУ-ын “Ханнс-Зайдел”-ийн сангийн тэргүүн, Төрийн сайд асан, хүндэт сенатч, доктор **Ханнс Цэтмайор**, тус сангийн Зүүн хойд Азийг хариуцсан хэлтсийн дарга **Вилле Ланге** нарыг 2011 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч хүлээн авч уулзан, эрүүгийн эрх зүйн шүүгч-сургагч багш, шүүгч нарын дунд зохион байгуулах сургалтыг үргэлжлүүлэх, түүнтэй холбоотой сургалтын гарын авлага боловсруулж, хэвлүүлэх болон хоёр талын цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

Тав. Сургалт, семинарын талаар

2011 оны байдлаар Улсын Дээд шүүх дараах сургалт, семинарыг зохион байгууллаа. Үүнд:

- 2011 оны 2 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд Төрийн тусгай хамгаалалтын газрын харъяа **“Их тэнгэр”** цогцолборт анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, Тамгын хэлтэс, албаны дарга нарын 2011 оны **нэгдсэн зөвлөгөөнийг**;
- 2011 оны 4 дүгээр сарын 18-наас 29-ний өдрүүдэд шүүгч Б.Бат-Эрдэнэ Ханнс Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” академитай хамтарч Хөвсгөл, Булган, Архангай аймгуудийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдэд **“Эрүүгийн хэргийг зүйлчлэхэд анхаарах зарим асуудал”** сэдэвт сургалтыг;
- 2011 оны 6 дугаар сарын 8-10-ны өдрүүдэд шүүгч Б.Бат-Эрдэнэ Төрийн ордонд зохион байгуулагдсан Хууль зүйн алба үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд **“Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд бодит үнэнийг тогтоох, мэтгэлцэх зарчмыг хуульчлан тусгасан нь”** сэдэвт илтгэл хэлэлцүүлж;
- 2011 оны 6, 7 дугаар саруудад Захиргааны хэргийн танхим, **“Ханнс-Зайдел”**-ийн сан, **“Эрх зүйн боловсрол академи”**-тай хамтран Аймаг, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, шүүгчийн туслахуудад **Говьсүмбэр, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Завхан** аймгуудад бүсчлэн **“Захиргааны гэрээ”, “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт, цаашид анхаарах асуудал”** сэдэвт бүсчилсэн сургалтыг;
- 2011 оны 10 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд Монгол Улсын Дээд шүүх Японы олон улсын хамтын ажиллагааны агентлагаас хамтран хэрэгжүүлж буй **“Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах”** төслийн хүрээнд эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх ээлжит 2 дахь удаагийн сургалтыг;
- 2011 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Иргэний хэргийн танхимын тэргүүн Б.Ундрах шинээр томилогдсон шүүгч нарт зориулсан **“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэхэд материаллаг хуулийг хэрэглэх нь”** сэдэвт сургалтыг;
- 2011 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Иргэний хэргийн танхим Нийслэлийн шүүхийн Иргэний хэргийн танхимтай хамтран **“Гэр бүл дэх насанд хүрээгүй хүүхдийн эрх зүйн хамгаалалт”** сэдэвт дугуй ширээний ярилцлагыг;
- Нийслэл, дүүргийн шүүхийн шүүгч нарт 2011 оны 11 дүгээр сарын 07-25-ны өдрүүдэд шүүгч Ц.Амарсайхан **“Гэм хор учруулснаас үүсэх үүрэг ба Иргэний хууль хэрэглэх, шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал”** сэдэвт сургалтыг;

- 2011оны 12 дугаар сарын 09-ний өдөр Иргэний хэргийн танхим МУИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхимтэй хамтран **“Эдийн бус хохирлыг арилгах эрх зүйн зохицуулалтын тухай”** сэдэвт уулзалт, ярилцлагыг;
- 2011 оны 12 дугаар сарын 16-ны өдөр шүүгч Л.Бямбаа хуульчийн гэрчилгээ бүхий шүүгч, захиргааны ажилтнуудад зориулсан **“Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”** сэдэвт сургалтыг
- 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Улсын Дээд шүүхийн **“Залуучуудын зөвлөл”**-өөс тус шүүхийн болон Нийслэл, дүүргийн шүүхийн захиргааны ажилтнуудад зориулсан **“Бизнесийн эрх зүйн орчин”** сэдэвт хуульчдад кредит олгох болон **“Залуу хүний эрхэмлэх 10 зүйл”** сэдэвт чөлөөт уулзалт-ярилцлагыг тус тус зохион байгуулж болон оролцон ажиллажээ.

Тайлангийн хугацаанд бусдаасаа илүү идэвх, зүтгэл, үр бүтээл гарган ажилласан шүүгч С.Нямжав, Д.Тунгалаг, Л.Атарцэцэг, референт З.Нацаг, Э.Баярбаатар, танхимын тэргүүний туслах Н.Дамдинсүрэн, шүүгчийн туслах Д.Алтанжигүүр, Х.Идэр, Т.Жавхлантөгс, шинжээч Л.Одончимэг, Н.Мөнгөнцэцэг, эмч А.Ариунболор, бичиг хүргэгч А.Пүрэвдулам, слесарь Б.Ширэндэв, мужаан С.Мөнхбаяр, үйлчлэгч Ц.Цэцэгсүрэн, Ц.Пагма, жолооч М.Рэнцэндорж нарт хамт олныхоо нэрийн өмнөөс болон хувиасаа талархал илэрхийлж, ажилд нь амжилт хүсье.

Эрхэм шүүгч, ажилтнууд аа!

Улирч буй 2011 онд бид амжилт бүтээл арвин байлаа. Ирж буй 2012 онд түүнээс ч их зүйлийг хийж, амжуулах шаардлагатай бөгөөд үүнд та бүхнийг идэвхи санаачлага, итгэл зүтгэл, үр бүтээл гарган ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Та бүхний цаашдын ажилд амжилт, эрүүл энхийг хүсье.